



**ЗАВХАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 09

Улиастай

**Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот  
үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "ж", 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, Компанийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.5 заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн "Амь-Ус" трейд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн "Амь-Ус" хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсүгэй.

2. "Амь-Ус" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны хэлтсийн дарга (Д.Үнэнхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УЛАМ-ОРГИХ

150210013